



МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨЛБӨРИЙН КАРТЫН ЗАХ ЗЭЭЛ

Сүүлийн жилүүдэд манай улсад төлбөрийн картын хэрэглээ эрс өсөн нэмэгдэж байгаа нь бэлэн мөнгөний гүйлгээг багасган бэлэн мөнгө тоолох, хадгалах, тээвэрлэх, хэвлүүлэх ажиллагааны зардал, эрсдлийг бууруулж, бэлэн мөнгөтэй холбоотой хулгай, дээрэм, авилгал, татвараас зайлсхийх зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдээс урьдчилан сэргийлж, банк санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд улам бүр ойртуулах зэрэг олон талын ач холбогдолтой юм. Өндөр хөгжилтэй орнуудад төлбөрийн хэрэгсэл болж өдөр тутмын хэрэглээнд хэвшсэн энэхүү бэлэн бус картын төлбөр тооцоог манай улсын арилжааны 10 банк үндсэн дөрвөн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд үйлчилж байна.

2005–2008 оны эхний хагас жилийн байдлаар карт эзэмшигчдийн¹ тоо (давхардсан тоогоор) 333 мянгаас 955 мянгад хүрч, карт ашиглагчдын² тоо 237 мянгаас 310 мянгад хүрч өссөн байна. Карт ашиглагчдын хувьд карт эзэмшигчдийн тооны өсөлтөөс бага хувьтай байгаа нь картын үйлчилгээний хүрээ хязгаарлагдмал, картын талаархи мэдлэг, ойлголт карт эзэмшигчдэд дутмаг, картын төлбөр тооцооны шимтгэл, хураамж харьцангуй өндөр байгаатай холбоотой байна.

Банкууд картын төлбөр тооцоонд ПОС, ПОБ, АТМ гэсэн ангиллын төхөөрөмжийг ашиглаж байна. ПОС (POS – point of sale буюу үйлчилгээний байгууллагуудад байршуулсан карт уншиж, гүйлгээ хийдэг төхөөрөмж) төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний нийт дүнг сүүлийн хоёр жилийн байдлаар харьцуулан үзэхэд багассан боловч,

1. 1 сард 5-аас доош картын гүйлгээ хийдэг хэрэглэгчийг карт эзэмшигч гэнэ.
2. 1 сард 5-аас дээш картын гүйлгээ хийдэг хэрэглэгчийг карт ашиглагч гэнэ.

ПОБ (POB - point of banking буюу банк, түүний салбар нэгжид байршуулсан карт уншиж, гүйлгээ хийх төхөөрөмж) төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний нийт дүн 7 дахин өсчээ. АТМ (автомат теллерийн машин)-ээр хийгдсэн гүйлгээний нийт дүн 4 дахин өссөн. Үүнээс үзэхэд ПОБ, АТМ-ээс карт эзэмшигчид мөнгөө бэлнээр авах сонирхол давамгайлж байгаа учраас эдгээр төхөөрөмжийн хэрэглээ ихэссэн байна.

Банкууд орон нутагт картын үйлчилгээ үзүүлж эхэлснээр нийт карт эзэмшигчдийн 25.5 хувийг, нийт карт ашиглагчдын 20.7 хувийг хөдөө орон нутгийн хэрэглэгчид болгож чадлаа. Орон нутагт ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүнг улсын нийт үзүүлэлтэд харьцуулахад ПОС гүйлгээний дүнгийн хувьд 0.4 хувь, ПОБ – 26.2 хувь, АТМ – 31.9 хувийг тус тус эзэлж байна.

Банкуудын картын үйлчилгээний шимтгэл, хураамж / картын төлбөр 0-20000 төгрөг, жилийн хураамж 1000-30000 төгрөг, нэгж гүйлгээний шимтгэл 40-500 төгрөг/-ийн хооронд хэлбэлзэж байна.

Монгол Улс дахь картын төлбөр тооцооны хэрэглээ болон банкуудын картын төлбөр тооцооны үйлчилгээ жил ирэх тутам өсч байгаатай холбоотойгоор төлбөр тооцоог түргэн шуурхай болгох, энэ төрлийн хэрэглээг хөхүүлэн дэмжих, картын үйлчилгээний төлбөр, хураамжийг бууруулан карт эзэмшигч, ашиглагчдын тоог нэмэгдүүлэх, картын хэрэглээний орчинг сайжруулах, картаар үйлчлэгч гэрээт байгууллагуудын тоо хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр Монголбанк нь банкууд, төрийн сан, холбогдох бусад байгууллагуудтай хамтран Төлбөр тооцооны үндэсний зөвлөл байгуулан ажиллаж байна.

Манай орны хувьд харилцан гүйлгээ дамжуулах боломж хомс олон сүлжээ байгаа нь системийн үр ашгийг бууруулж, хэрэглэгчдийн хувьд хүндрэл үүсгэн, улмаар төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх боломжийг хязгаарлаж, бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Иймд бэлэн бус төлбөр тооцооны шинэ дэвшилтэт хэрэгслүүдийг нэвтрүүлэх, нийтийн хүртээл болгоход Монголбанкны дэргэдэх Төлбөр тооцооны төвд банкууд нэгдэн, ажиллахаар төлөвлөж байна. Ингэснээр гүйлгээний шимтгэл хураамжийг буруулан, аль ч ПОС, ПОБ, АТМ-ээр харилцагч, үйлчлүүлэгчид үйлчлүүлэх өргөн боломжийг бий болгох юм.